

МОНГОЛЧУУД ЭРХ ЧӨЛӨӨ, ТУСГААР ТОГТНОЛЫНХОО ТӨЛӨӨ ТЭМЦСЭН НЬ

Бүлэг: XVIII-XX зууны эхэн үеийн Монгол Сурагчийн овог нэр:.....

Эхэлсэн.... он.....сар.....өдөр....цаг
Дууссан.... он.....сар.....өдөр....цаг



1755-1758 оны Монголчуудын эрх чөлөө, тусгаар тогтнолын хөдөлгөөний шалтгаан, үйл явц өрнөлийг судлах ба түүхэнд үлдээсэн сургамж үр дүнг үнэлнэ. Эх орон, эрх чөлөө тусгаар тогтнол бол монгол хүн бүрийн эрхэм үнэт зүйл мөн.

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 77-81-р талыг ашиглаарай.)

8.3а

1. Яагаад 1755-1758 онд Манжийг эсэргүүцсэн зэвсэгт тэмцэл өрнөсөн бэ?

а) Сурах бичгийн 77-р талыг ашиглан мэдээллийг нөхнө үү.

Монголчууд (1)_____улсын эрхшээлд орсноор эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэх шаардлага тулгарав. XVIII зууны дунд үеэр (2)_____, Халх (Хотгойд), (3)_____ -ын зарим ноёд Манжийн эсрэг нэгэн зэрэг бослого гаргаж, Их Монгол Улсаа сэргээн байгуулахаар нууцаар хэлэлцэн тохирчээ. Үүний илрэл нь (4)_____оны зэвсэгт бослого байв.

Манж Чин улс бослого гаргах сэжиг олж мэдээд, тэднийг хүчээ нэгтгэхээс сэргийлэх арга хэмжээ авчээ. (5)_____ Хан-Хатан голын Тэлэнгэд нарыг дагуулах үүрэг өгч явуулахын хамт Сэвдэнбалжирыг хэрэг зөвлөнө гэж (6)_____ дуудан аваачаад хэргэм зэргийг нь эвдэн, гэрийн хорионд оруулжээ. Улмаар (7)_____ ч мөн “хэрэг зөвлөнө” гэж Бээжинд яаралтай дуудав.

б) Түүхэн зүтгэлтнүүдийг нэрлэнэ үү. Бидэнд юу захиж үлдээсэн бэ?

Зураг-1



.....
.....
.....
.....


.....
.....
.....
.....




.....

.....


в) Зүүнгарын хаант улсад бослого хэрхэн өрнөсөн бэ? Он тооллын шугамд тэмдэглэнэ үү.



г) Халх Монголд бослого хэрхэн өрнөсөн бэ? Он тооллын шугамд тэмдэглэнэ үү.




д) Хойдын Амарсанаа, Хотгойдын Чингүнжав нарын бослого тэмцэл өрнөсөн газар нутгийг газарзүйн зурагт дүрсээр тэмдэглээрэй.




Хотгойдын Чингүнжав

Хойдын Амарсанаа

е) Монголчууд харийн дарангуйллын эсрэг хэрхэн тэмцэж байсан бэ? Тэмцлийн хэлбэрүүдийг гүйцээн бичээрэй.



в) Үгийн сүлжээг бөглөн Манжийн үеийн Монголын засаг захиргааны онцлогийг илүү сайн мэдэж аваарай.




Босоогоор

1. 150 цэрэг эр гаргах засаг захиргааны нэгжийг юу гэж нэрлэдэг вэ?
2. Сумыг ямар албан тушаалтан захирах вэ?
3. Чуулганыг ямар албан тушаалтан удирдах вэ?
4. Хутагтуудын шавь нарын засаг захиргааны үндсэн нэгж нь юу байсан бэ?
5. Аймгийг ямар цолтон удирдах вэ?
6. Хутагтуудын харьяат албатыг нэрлэх нэр

Хөндлөнгөөр

1. 150 эр хүрэхгүй өрхтэй сумыг юу гэж нэрлэдэг байсан бэ?
2. Хошууг ямар албан тушаалтан захирах вэ?
3. Чуулган хэдэн жилд нэг удаа чуулдаг байсан бэ?
4. 1725 онд Халхад ямар аймгийг нэмэн байгуулсан бэ?
5. Аймгийн цэргийн хэргийг ямар албан тушаалтан мэддэг байв?
6. Өвөр Монголд , Ар Монголд тус бүр хэдэн чуулган байсан бэ?
7. Хошууны ноёд, тайж нарын захирах ардыг юу гэж нэрлэдэг вэ?

г) Хошууны тамгын газарт ажиллах албан тушаалтнуудыг нөхөж бичнэ үү.



д) Сумын энгийн ард хэрхэн хуваагддаг байсан бэ?



3. Мэдээллийг уншаад асуултад хариулаарай.

8.26

Мэдээлэл:1

Монголчууд Манжийн хаанд болон улсад есөн цагаан, Бээжинд жасаалах, сүрэг адуулах, албан тарианы, ангийн үсний, зоог шүүсний, цэрэг, харуулын, өртөөний, хурал номын, засаг захиргааны зардал хэрэглэлийн гэх мэт төрөл бүрийн алба залгуулдаг байжээ.

а) Монголчуудын залгуулж байсан албанаас хамгийн хүнд нь аль нь вэ? Баримтаар дэлгэрүүлж тайлбарлаарай.

.....
.....
.....

б) Алба, гувчуур хоёр ямар ялгаатай вэ? Тайлбарлаарай.

.....
.....
.....

4. Мэдээллийг уншаад асуултад хариулаарай.

8.36

Мэдээлэл:2

XIX зууны эцсээр ат 30 лан, ингэ 20 лан, морь 15-20 лан, гүү 9-11 лан, шар 20 лан, үнээ 15-20 лан, эр хонь 1.5-2 лан, эм хонь 1.5 лан орчим үнэтэй байв. XX зууны эхэн гэхэд Ар Монголоос худалдаачид 100 мянган үхэр, 70000 адуу, 3000 тэмээ, 800000 бог малыг хөлөөр нь гаргаж байжээ.

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 85 тал)

Тайлбар:Хүндийн хэмжээ; нэг лан 37,3 граммтай тэнцэнэ.

а) Хятад худалдаачдаар дамжин хэдий хэр хэмжээний баялаг урсан гарч байсныг тооцоолон бодоод үнэлэлт дүгнэлт хийгээрэй.

.....
.....
.....



МОНГОЛД БУРХНЫ ШАШИН ӨРГӨН ДЭЛГЭРСЭН НЬ

Улс төр, нийгмийн олон шалтгааны үр дүнд монголын түүхийн энэ үед бурхны шашин өргөн дэлгэрсэн юм. Бурхны шашин нь монголчуудын ахуй амьдрал соёлд ихээхэн өөрчлөлт авчирсан.

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 88-92-р талыг ашиглаарай.)

8.1а

5. Он дарааллын хүснэгтэн дэх мэдээллийг ашиглан асуултанд хариулаарай.

Он	Үйл явдал
НТӨ VI зуун	Бурхны шашин Энэтхэгт үүссэн.
VII зуун	Бурхны шашин Түвдэд дэлгэрсэн.
XIV зууны сүүл, XV зууны эхээр	Бурхны шашны шарын урсгал дэлгэрэв. Энэ урсгалыг үндэслэгч нь Түвэд лам Зонхов юм.
НТ XVI зууны II хагас	Монголд бурхны шашин дэлгэрсэн.


а) Монголд бурхны шашны аль урсгал, ямар улсаар дамжин орж ирсэн бэ?

.....
.....
.....

б) Графикийг ажиглаарай. Хүн амын 21% нь лам нар байсан. Тэгвэл нийт хүн амын тоог олоорой.



Бодолт:



6. Дээрх зураг, газарзүйн зураг, сурах бичгийн мэдээллийг ашиглан хүснэгтийн асуултад хариулаарай.

8.2в

	Эрдэнэ зуу хийд	Амарбаясгалант хийд	Манзушир хийд
Хэн, хаана, хэзээ байгуулсан бэ?			
Одоогийн аль аймаг, сум бэ?			
Хичнээн лам хуваргатай байсан бэ?			
Ямар онцлогтой вэ?			

7. Бүдүүвчийн мэдээллийг ашиглан асуултанд хариулаарай.

8.2г



Монголд бурхны шашин өргөн дэлгэрэхэд олон хүчин зүйл нөлөөлжээ



а) Бурхны шашин Монголын ихэс дээдсийн дэмжлэгийг ямар учраас авч чадсан бэ?

.....

.....

.....

.....

б) Бурхны шашин Монголын жирийн олон түмний дэмжлэгийг авахад нөлөөлсөн хүчин зүйлсийн жагсаалт гаргана уу.

.....

.....

.....

в) Шашин өнөөгийн нийгэм болон хүмүүсийн амьдралд ямар үүрэг гүйцэтгэж байна вэ?


.....

.....

.....

8. “Хутагтын дөрвөн үнэн”-нд хамаарах өгөгдлийг гүйцээгээрэй.

8.16





XVIII-XX зууны эхэн үеийн Монголчуудын амьдрал

XVIII-XX зууны эхэн үеийн монголчуудын амьдралын хэв маяг, дүр төрх зарим талаар өөрчлөгдсөн. Үүнд харь гүрний нөлөө зарим талаар нөлөөлсөн.

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 93-95-р талыг ашиглаарай.)

8.3в

9. Баримтын мэдээллийг ашиглан асуултад хариулаарай.

Баримт:1

Оросын дипломатч И.Я.Коростовец "...монгол хүн гүндүүгүй, бодь сэтгэл өвөрлөж, хээр талаар морин дэл дээр өссөн шигээ бүхий л амьдралаа өнгөрүүлдэг, хүүхэд шиг зантай" гэж тодорхойлжээ.

Монгол хүн сэтгэл санааны хувьд хамгийн тайван хүмүүсийн тоонд орно. Тэд аливаад яарахыг огт боддоггүй. Хэзээ нэг цагт болж л таарна гэж үзнэ. Оюун ухааны хувьд монголчууд маш авхаалжтай, эелдэг сайхан сэтгэлтэй, нөхөрсөг, зочломтгой ард түмэн бөгөөд манж, хятадын нөлөөгөөр монголчууд үсээ хусах болж, зөвхөн ар дагзандаа бага зэрэг гээг үлдээх болсон байна. Ар дагзандаа гээгтэй болсон нь манжийн үед буй болсон уламжлал бөгөөд энэ нь манжид захирагдаж буйг гадаад төрхөөрөө илэрхийлж байсан хэрэг болно.

(Монголчууд XXзууны эхэнд. Зурагт түүх. УБ.,2011, т.38)

Баримт:2

Хот айлын зохион байгуулалт нь XVIII-XX зуунд хэлбэршин тогтсон монголчуудын аж ахуйгаа хөтлөн явуулах гол хэлбэр байв. Энэхүү хэлбэр нь монголчуудын өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд ч нөлөөлөх болжээ. Тухайлбал, ан авд мордох, тариа тарих, овоо тахих гэх мэтийг нэрлэж болох юм. Монголчууд нүүдэллэхэд ямагт бэлэн байдаг. Тэдний морин тэрэг нь нүүдлийн гол хэрэгсэл юм. Монгол хүн нүүдэл хийхийг хүнд бэрхээс илүүтэй дураар оршин амьдрах өөрийн жам ёсны зүйл хэмээн ойлгож, түүндээ тохирсон ахуй соёлыг нэгэнтээ буй болгожээ.

(Монголчууд XVII-XX зууны эх үе. Зурагт түүх. УБ., 2014, т.210)

XVIII-XX зууны эхэн үеийн монгол хүний талаар төсөөлөн оюуны зураглал хийгээрэй .

Гадаад төрх

.....
.....
.....
.....
.....

Зураг-5

Зан авир

.....
.....
.....
.....
.....

Амьдралын хэв маяг

.....
.....
.....
.....
.....
.....

Оюун ухаан

.....
.....
.....
.....
.....



XVIII-XX зууны эхэн үеийн монголын соёл




XVIII-XX зууны эхэн үеийн монголчууд нүүдлийн соёл иргэншлээ хадгалан оршиж байв. Энэ үед Монголын уламжлалт эдийн болон оюуны соёл олон талаар баяжин хөгжсөн. Үндэсний соёл нь тусгаар тогтнол, эв нэгдэл, эх оронч үзэлтэй салшгүй холбоотой.

8.2д


(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 96-100-р талыг ашиглаарай.)

10. Тухайн үеийн сургууль бүрд юу заадаг байсныг хооронд нь сумаар зөв холбоорой.



а) ЮНЕСКО-гийн соёлын өвд бүртгэгдсэн өвүүдийг он тооллын шугамд тэмдэглэнэ үү.

Он тооллын шугам:



Монголчууд цаазалсан бэлчээр газрыг зоргоор хагалж тариулах болбоос ван, бэйл, бэйс, гүн, жич туслагч тайж нарыг журганаас чангалан ял хэлэлцмүй. Тайж болбоос шууд түшмэл эвд. Түшмэл, цэрэг, сул монгол болбоос хоёр сарын дөнгө дөнгөлж, зуун ташуур занч. Хагалсан тариаг бүрэн ширэлдүүлж, бэлчээр болго...

Нэгэн зүйл. Хаалгын дотор (Цагаан хэрэм) суусан хошууны хүн, иргэд (хятад хүмүүс) хаалга гарч, монгол газарт тариа (газар) хагалж болохгүй...Аливаа засаг ба засаг бус хан, ван, бэйл, бэйс, гүнүүд зоргоор иргэнийг элсээн хурааж, тариа хагалбаас нэгэн иргэнээс аравт хүрснийг нь нэгэн жилийн пүнлүү хас.

(Л.Жамсран.Монголын түүхийн дээж бичиг.УБ.,1992)

б) Эх сурвалжид юун тухай өгүүлж байна вэ?

.....

Дараах нэр томъёог тайлбарлана уу. (Журган, хаалга, дөнгө, пүнлүү)

.....

Дур зоргоор тариалсан хүмүүст хатуу шийтгэл оноосны учир юу вэ?

.....

Монголын талаарх Манж Чин гүрний бодлого өөрчлөгдөв



Монголын талаарх Манж Чин гүрний уламжлалт бодлого өөрчлөгдөн шинэ засгийн бодлого хэрэгжүүлсэн нь Монголчууд тусгаар тогтносон төр улсаа сэргээх тэмцлийн урьдач нөхцөлийг бүрдүүлсэн юм.

8.2e

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 101-105-р талыг ашиглаарай.)


11. Мэдээллийг уншаад Зураг-6 ашиглан даалгаврыг гүйцэтгээрэй.

Мэдээлэл:1

XIX зууны 90-ээд онд дэлхийн их гүрнүүд Манж Чин улсыг нөлөөнийхөө хүрээнд хэсэглэн хуваав. Гадаадын нөлөөгөөр XX зууны эхээр Манж Чин улсад капитализмын хөгжил түргэсэв. 1898-1900 онуудад гадаадынхныг эсэргүүцсэн бослого дэгдсэн ч 1901 онд дарагджээ. Япон, Орос, Герман, АНУ, Франц, Англи, Австри-Унгар, Итали зэрэг 8 улстай хийсэн дайнд ялагдаж, их хэмжээний дайны төлбөр төлөхөөр болов. Шинэ хөрөнгөтнүүд феодалын дэглэм, харийн хүчирхийлэлд автсан Манж Чингийн засаглалыг өөрчлөхийг зорив.



а) XIX зууны 90-ээд онд Манж Чин гүрний газар нутгийн 4 захыг тэмдэглээрэй.



б) Энэ үед Манж Чин гүрний гадаад орчин ба дотоодод ямар өөрчлөлтүүд гарсан бэ? Хүснэгтийг бөглөнө үү.

Гадаад орчин	Дотоод нөхцөл

Мэдээлэл:2

Манж Чингийн хаан 1901 онд зарлиг гаргаж нийгмийн хямралаас гэтлэх зорилгоор “Шинэ бодлого” хэмээх шинэтгэлийг хэрэгжүүлэхээр болсон юм. Энэ хүрээнд Монгол, Төвөд зэрэг хязгаар оронд шинэтгэл хийхээр төлөвлөснийг нь монголчууд “Шинэ засгийн бодлого” гэж нэрлэж байлаа. Түүний зэрэгцээ “Иргэнийг шилжүүлэн суулгаж хязгаарыг бэхжүүлэх” хэмээх бодлогоор олон мянган хятадуудыг нүүлгэн суурьшуулж эхэлжээ. Тэдгээр бодлогыг хэрэгжүүлэхэд Монголын олон хошуудын эрх баригчид аргагүйн эрхэнд хамрагдах болов. Тухайлбал, монголчуудын бэлчээр нутгийг тариалангийн газар болгох зорилгоор олон зүйлийн судалгаа байцаалт хийх болов.

12. Шинэ засгийн бодлого гэж вэ?

8.2ё

.....

13. Мэдээллийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

8.3г

Мэдээлэл: 3

1906 онд Бээжин хотноо “Нүүдлийн иргэдийн хэргийг эрхлэх хороо” байгуулан, Монгол, Оросын хилийн дагуу нутагт хятад тариачдыг ирүүлэн суурьшуулж эхэлсэн юм.

Манж Чин улс Монголд шинээр цэрэг бэлтгэх газар, цагдан сэргийлэх хороо, ой модны түрээсний ерөнхий ба салбар хороо, эрүүлийг хамгаалах хороо, хэмжээт засгийн явдлыг сүвэгчлэн бэлтгэх газар, гадаадтай харилцах хороо, худалдааны явдлыг хянан байцаах хороо гэх зэрэг хорь орчим албан газрыг байгуулсан юм.

Монголчуудын аж ахуйн орлого, түлээ мод болон бусад тээврийн зүйлээс гааль хурааж эхэлжээ.

а) Манж Чин улсын авч хэрэгжүүлсэн бодлого монголчуудад хэрхэн нөлөөлсөн бэ? .

.....
.....
.....
.....

б) “Үндсийг таслах, шашныг устгах бодлого”, “язгуурын ёсоо журамлах” хэмээсний утгыг тайлбарлан бичээрэй.

.....
.....
.....
.....



Зураг-9

8.2ж

14) Энэ зургийг хэн хэдэн онд ямар зорилгоор бүтээсэн бэ?

Зургийн өгүүлэмж зурагт дүрсэлсэн үеийн бодит байдалтай хэр нийцэж байна вэ?

.....
.....
.....
.....




ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС



Хүүхдүүд та бүхэн өөрийгөө үнэлэхдээ “Өөрийн үнэлгээ” гэсэн хүснэгтэд даалгаврын дугаараа тавиарай. Жишээ нь: Бүрэн хийж чадсан даалгаврынхаа дугаарыг “Би хийж дууссан” гэсэн нүдэнд тавиарай.



1. Өөрийн үнэлгээ

 Би хийж дууссан	 Би эргэлзэж байна	 Надад дууламж хэрэгтэй байна



2. Багшийн үнэлгээ

<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>

Аж үйлдвэрийн хувьсгал

Бүлэг: XVIII-XX зууны эхэн үеийн өрнө

дахин

Сурагчийн овог нэр:.....

Эхэлсэн.... он.....сар.....өдөр....цаг

Дууссан.... он.....сар.....өдөр....цаг




Аж үйлдвэрийн хувьсгал буюу гар үйлдвэрлэлээс машинт үйлдвэрлэлд шилжих үйл явц нь Барууны орнуудын урт хугацааны, харьцангуй тогтвортой, өөрийгөө хангах эдийн засгийн эхний оролдлого байв. Аж үйлдвэржилт нь нийгэм, хүмүүсийн амьдралд чухал хувь нэмэр авчирсан.

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 106-110-р талыг ашиглаарай.)

1. Графикийг ажиглаад асуултад хариулаарай.

8.3a

Хүн амын өсөлт (саяаар)
Их Британи



-1700-1851 онд Британийн хүн ам хэд дахин өссөн байна вэ?

-Хүн амын өсөлт нийгэмд ямар асуудал үүсгэсэн бэ?

-Тухайн үеийн гар үйлдвэрлэлээр хүн амын эрэлт, хэрэгцээг хангаж чадах байсан уу?

.....

.....

.....

2. Дараах хүмүүс хэдэн онд юу зохион бүтээсэн бэ? Тэдний бүтээл нийгэмд ямар өөрчлөлт авчирсан бэ?

8.1a



Миний нэрийг Жон Кей гэдэг. Миний бүтээл давуу үйлдвэрлэлийг үлэмж нэмэгдүүлсэн юм. Би юу зохион бүтээсэн бэ?

.....

.....

.....

.....

.....

Миний нэрийг Жеймс Хартрийвс гэдэг Би юу зохион бүтээсэн бэ?



.....

.....

.....

.....

.....




Миний нэрийг Эдмунд Картрайт гэдэг. Би юу зохион бүтээсэн бэ?

3. Үйлдвэр, тээвэр, хөдөө аж ахуй, хотжилт, хүн амын өсөлтөд хэрхэн нөлөөлсөн бэ?

8.36

Нүүрс



.....

.....

.....

.....

Сувгаар тээвэрлэх



.....

.....

.....

.....

Байгаль орчинд



.....

.....

.....

.....

Үйлдвэржилтийн үр дүн



.....

.....

.....

.....

4) Баримтыг уншаад асуултад хариулаарай.

8.2a

Мэдээлэл:

Тухайн үед үйлдвэрийн ажилчид 14-18 цаг ажиллаж байжээ. Хүүхдийн хөдөлмөрийг насанд хүрэгчдээс багаар үнэлж, хямдхан ажиллуулдаг байв. Зарим үйлдвэр тоног төхөөрөмжөө засуулахад тохиромжтой учир хүүхдийг насанд хүрэгчдээс илүү авч ажиллуулах сонирхолтой байв. Хөвөн утас ээрч буй хүүхдүүд хөл нүцгэн ажилладаг байв. Тухайн үед хүүхдүүд сургуульд сурах боломжгүй, гэр бүлдээ туслах зорилгоор долоо хоногийн зургаан өдөр үйлдвэрт ажиллана. Тэдний ажиллах нөхцөл хүнд, ядарч туйлдан ажлаасаа тарахад харанхуй, заваан, аймшигтай орчин угтдаг байлаа. Жишээ нь: Вильям Купер, 10 настай эгчийн хамт нэхмэлийн үйлдвэрт ажилладаг. Ажил нь өглөө 5 цагт эхэлдэг. 12 цагаас 40 минутын цайны завсарлагатай бөгөөд үүнийг маш их хүлээдэг байв. Тэд унтаж ер болохгүй, ташууртай хянагч хяналт тавьдаг байв ... 18 цагаас оройн хоолоо иддэг. 21 цагт ажил нь дуусдаг боловч Купер эгчийн хамт өөр нэг газар ажиллаж, 11 цагт гэртээ харьдаг байжээ.

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 108 тал)

а) Үйлдвэрт яагаад хүүхдийн хөдөлмөрийг ашигладаг байв? Тэдний ажлын нөхцөл, цалин хөлс ямар байв?

.....

.....

б) Тэр үед ийм нөхцлийг хүүхдийн эрхийн зөрчилд тооцож байв уу? Одоо ийм нөхцлийг хүүхдийн эрхийн зөрчил гэж үзэх үү? Ямар ямар эрх зөрчигдөж байв?

.....

.....



Шинжлэх ухааны ололт, нээлтүүд

Шинжлэх ухааны ололт нээлтүүд нь хүн төрөлхтний томоохон өөрчлөлт авч ирсэн. Шинжлэх ухааны хөгжил, түүний үр дүн, ололт нээлтүүд нийгмийн хөгжлийг урагшлуулагч чухал хүчин зүйл болдог. Шинэ үед гарсан шинжлэх ухааны нээлтүүд өнөөдөр ч бидэнд ач тусаа өгсөн хэвээр байна.

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 111-114-р талыг ашиглаарай.)

8.3в

5) Сурах бичгийн 111-112-р талын мэдээллүүдийг судлан шинжилж, нэгтгэн дүгнэж, хүснэгтийн асуултад хариулаарай

Нээлт	Он цаг, улс, нээлт хийсэн хүн	Ач холбогдол

6. Шинжлэх ухааны нээлтээрээ дэлхийд тэргүүлж байсан 3 орныг тэмдэглэнэ үү.

8.2б



Кирилл	Код	Кирилл	Код	Кирилл	Код
А	••	Л	••••	Х	••••
Б	••••	М	••	Ц	••••
В	•••	Н	••	Ч	••••
Г	•••	О	••••	Ш	••••
Д	•••	П	••••	Щ	••••
Е	•	Р	•••	Ь (ь)	••••
Ж	••••	С	•••	Ы (ы)	••••
З	••••	Т	•	Э	••••
И	••	У	•••	Ю	••••
Й	••••	Ф	••••	Я	••••
К	•••				

- Тэмдэгт дотор цэгүүд болон зурааснуудын хоорондын зай нь нэг цэг (нэг нэгж) урттай байна.
- Үсэг хоорондох ялгаа нь гурван нэгж урт байна.
- Үгсийн хоорондын зөрүү нь долоон нэгж урттай.

7) Морзын цагаан толгойг ашиглан дараах үгсийг кодлоорой.

8.3г

Аав



• - • - • - -

Ээж

Би

Ах

Дуу



Зураг-12



8.2в

- 10) График, диаграммын мэдээллийг ажиглан дараах асуултад хариулна уу.
- XVIII зуунд Францын нийгэм ямар давхаргаас бүрдэж байсан бэ? 1, 2, 3-р давхаргад ямар хүмүүс багтаж байсан бэ?
 - Аль давхарга нь хамгийн олон тоотой байсан бэ?
 - Ачааны хүндийг хэн үүрч байв?
 - Шог зурагт XVIII зууны Францын нийгмийн байдлыг хэрхэн шогчилсон байна?

.....

.....

.....

.....

.....

.....

8.3д

11) Хувьсгалуудын үр дүнд баталгаажсан хүний эрхийн бичиг баримтуудаас орчин үеийн ардчилсан үндсэн хуулиудад тусгалаа олсон хүний эрхийн түгээмэл зарчмуудыг ялгаарай (өөрийн орны ҮХ-ийн жишээгээр).

Баримт 1

Хүн бүрт тэгш эрх заяагдсан юм. Хүн бүхэн өөрт заяагдсан эрх чөлөөтэй амьдрах, жаргалыг хүсэх эрхээ эдлэх ёстой
Хүн бүр тэгш эрхээ эдлэх боломжийг Засгийн газар бүрдүүлж өгөх ёстой. Хэрвээ Засгийн газар үүнийг хэрэгжүүлж эс чадвал ард түмэн түүнийг огцруулж, шинэ Засгийн газрыг сонгох эрхтэй.

- АНУ-ын “Тусгаар тогтнолын тунхаг” /1776/-аас

Баримт 2

Хүн бүр эрх чөлөөтэй, тэгш эрхтэй төрдөг. Нийгмийн ялгаа нь зөвхөн нийтэд ашигтай байх зарчим дээр үндэслэсэн байх ёстой.
Ямар ч улс төрийн холбооны зорилго нь хүний төрөлх хийгээд халдашгүй эрхийг хамгаалах явдал юм. Ийм эрхийн мөн чанар нь хүн эрх чөлөөтэй байх, өмчтэй байх, аюулгүй байх, дарлал мөлжлөгийг эсэргүүцэх болно.


- Францын “Хүний ба иргэний эрхийн тунхаглал” /1789/-аас

.....

.....

.....

.....



Зураг-12 12) Өмнөд Америкийн орнуудыг ямар улсууд колоничилж байсныг тодорхойлоорой.

8.2г



Зураг-13

13) Өмнөд Америкийн ихэнх орон хэзээ тусгаар тогтнолоо олсон байна вэ? (зуун, эхэн хагас, сүүл хагас ойлголтыг ашиглаарай)

8.2д

14) I Петр хааны шинэчлэлээр оюуны зураглал хийгээрэй.


8.3e




Засаглал




Эдийн засаг



I Петр хаан



Колоничлолын бодлого



Дайн байлдаан

I Петр хаан хуанлийн ямар шинэтгэл хийсэн бэ? 1700 он Ертөнц бүтээгдсэн эриний хэдэн он бэ? 7 дугаар ангийн мэдлэгээ ашиглаарай.



Санкт-Петербургийг оросын нэрт зохиолч А.С.Пушкин "Европыг цонх" гэж харах нэрлэсэн яагаад бэ? Газарзүйн байрлалтай нь холбон тайлбарлаарай.

НАПОЛЕОН БОНАПАРТ БА ФРАНЦЫН ЭЗЭНТ ГҮРЭН



Наполеон Бонапарт бол Францын хувьсгалын үр дүнд тодорсон цэрэг, улс төрийн агуу удирдагч байсан бөгөөд Францын хувьсгалыг аварсан ч бүгд найрамдах засаглалыг халж Францын эзэнт улсыг байгуулсан.

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 123-125-р талыг ашиглаарай.)

8.2е

15) Наполеон Бонапарт ба Францын эзэнт улсын талаар сурах бичгийн мэдээллийг ашиглан танилцуулга хийгээрэй.

Амьдралын эхэн үе	Францын нийгмийн байдал
Тодрон гарсан нь	Төрийн эргэлт
Бодлого, үйл ажиллагаа	
Наполеон Бонапартын аян дайн ба Францын агуу армийн ялагдал	




ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС



Хүүхдүүд та бүхэн өөрийгөө үнэлэхдээ “Өөрийн үнэлгээ” гэсэн хүснэгтэд даалгаврын дугаараа тавиарай. Жишээ нь: Бүрэн хийж чадсан даалгаврынхаа дугаарыг “Би хийж дууссан” гэсэн нүдэнд тавиарай.



1. Өөрийн үнэлгээ

 Би хийж дууссан	 Би эргэлзэж байна	 Надад дууламж хэрэгтэй байна



2. Багшийн үнэлгээ

<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>

XVIII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН ДОРНО ДАХИН

Бүлэг: XVIII-XX зууны эхэн үеийн дорно дахин

Сурагчийн овог нэр:.....

Эхэлсэн.... он....сар....өдөр....цаг
Дууссан.... он....сар....өдөр....цаг



Шинэ үеийн эхэнд Дорно дахин нь дэлхийн хүн ам олонтой, баян нутаг дэвсгэртэй байв. Дорно дахинд (Ази, Хойд Африк) дэлхийн хүн амын 68% нь аж төрж байлаа. Европчууд хүрэлцэн ирсэн нь Дорно дахины нөхцөл байдлыг эрс өөрчилж, оршин буй хүчний тэнцвэрт байдал, үүний хамт үнэт зүйлс, улс төрийн тэргүүлэх үзэл баримтлалынх нь бүх тогтолцоог эвдсэн юм.

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 126-132-р талыг ашиглаарай.)

8.1a

1) Чин улсын бүрэлдэхүүнд багтаж байсан газар орныг тохирох тоотой нь зөв харгалзуулаарай.



Зураг-14

➤ 2	➤ Өвөр Монгол
➤ 5	➤ Манжуур
➤ 4	➤ Түвэд
➤ 1	➤ Ар Монгол
➤ 3	➤ Шинжаан

8.2a

2) Эх сурвалжийг зохиогчид хэн бэ? Бид тэдний тухай юу мэдэх вэ? Тэд хятад хүмүүсийг юунд уриалж байна вэ? Яагаад ийнхүү тэмцэх болов? Тэдний тэмцэл юугаар өндөрлөснийг таамаглаж болох уу?

Манай алдар сууг өргөцгөө. Та хэнтэй нэгэн дээвэр доор амьдарч чадахгүй гэдгээ тунхаглацгаая. Өөрийн төр улсдаа хүндэтгэлтэй хандацгаа. Тэд (манж нар) манай ард түмнийг яаж өлсөж, үхэж, оргож зугтаж, гэр орноо орхиж яс арьс болж байгааг тайван ажиглаж байна. Манж нар хятад хүмүүсийн өөрийн авьяас чадварыг шавхан дуусгахыг эрмэлзэж байгаа юм. Түшмэдүүд бэлэг сэлт барьж, ял шийтгэлээс мөнгөөр чөлөөлөгдөж, баячууд улам баяжиж, алдартай хүмүүс бүхий л найдвараа алдаж байна. Шударга ёсыг нэр төрөө болгосон хүмүүс хятад орноо хүчирхэг болгох, шинэ шинэ самууныг өдөөж, хүмүүсийг гэр бүлээр нь, төрөл садангаар нь хөнөөж буй манж нарын эсрэг тэмцэхийг уриалж байна. (Тайпинчуудын ятгах хуудаснаас)

.....

.....

.....


.....

.....

.....

8.3в

6) Моголын эзэнт улсын уналт хэрхэн өрнөсөн бэ? Он тооллын шугамд тэмдэглэнэ үү.



8.3г

7) XVIII-XIX зууны Османы эзэнт улсын талаар дараах хүснэгтийн дагуу дүгнээрэй.

	Османы (Оттоманы) эзэнт улс
Эдийн засгийн байдал	
Улс төрийн байдал	

8.1б

8) Дараах ойлголтуудыг тайлбарлаарай.

Заминдарууд-.....

Танзимат-.....

XVIII-XX зууны эхэн үеийн өрнө дахины улс орнуудын амьдрал, соёл



XVIII-XX зууны эхэн үеийн өрнөдийн хүн амын аж байдал, амьдралын хэв маяг, дүр төрх олон талаар шинэчлэгдэн өөрчлөгдсөн. Энэ үеийн өрнөдийн улс орнууд соёлын хөгжил шинэ шатанд гарч, орчин үеийн соёлын үндэс суурь тавигдсан.

8.3д

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 139-142-р талыг ашиглаарай.)

Мэдээлэл: XVIII зууны дунд үеэс эхэлсэн хөдөө аж ахуйн хувьсгалын үр дүнд хүнсний үйлдвэрлэл үлэмж хэмжээгээр нэмэгдлээ. Үр ашиг нь ихээхэн дээшилснээр хүн ам цаашдаа улам олшров. Тариаланчид хотод очиж үйлдвэрт ажилд орсноор аж үйлдвэрийн хувьсгалын хөдөлгөх хүч болов

(Адам Харт Девис. Дэлхийн түүх. Бүрэн хэмжээний зурагт лавлах. ДК, MON sudar. УБ.,2010. т.290)

12) Хотын хүн ам нэмэгдсэн нь нийгэмд хэрхэн нөлөөлсөн бэ? Таамаглал дэвшүүлээрэй.

Эерэг тал	Сөрөг тал

8.3е

13) Мэдээллийг уншаад асуултад хариулаарай. Хүмүүсийн амьдралын хэв маягт гарсан өөрчлөлт нь соёл урлагт хэрхэн нөлөөлсөн бэ?

Мэдээлэл: XIX зууны үеэс хүмүүсийн амьдралын хэв маягт гарсан нэгэн өөрчлөлт нь амралт, чөлөөт цаг гэсэн хуваарь бий болов. Хүмүүсийн орлого нэмэгдэх тусам чөлөөт цагаа өнгөрүүлэх зоогийн газар, театр, үзвэр, спортын газрууд бий болжээ.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

XVII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН ДОРНО ДАХИНЫ УЛС ОРНУУДЫН АМЬДРАЛ, СОЁЛ



Дорно дахины ард түмэн өөрийн гэсэн өвөрмөц соёлыг бий болгосон. Дорно дахины ард түмний амьдрал, соёл түүхийн бүхий л цаг үед баяжин хөгжсөөр ирсэн. Амьдрал соёлын хөгжилд нийгэм, улс төрийн нөхцөл байдал нөлөөлдөг.

8.3ё

(Ц.Гантулга нар. Түүх VIII.УБ., 2019. 143-146-р талыг ашиглаарай.)

14) Тухайн үед Хятад хүн үсээ хусуулан тав гэзэг тавьж байсан нь ямар учиртай вэ?



Зураг-16

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

8.3ж

15) Япон хүнийг тодорхойлоорой. Бид тэднээс ямар зан чанарыг нь суралцаж болох вэ?

Мэдээлэл: Японы гар урчууд нь ажилдаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд ашиг орлого, нэр алдраас илүү чанар сайтай эд хийхийг эрмэлзэнэ.



Зураг-17

.....
.....
.....
.....

16) XIX зуун гэхэд Энэтхэг хөвөн, улаан буудай, цай зэрэг бүтээгдэхүүнүүдийг экспортод гаргах болсон. Гэвч энэтхэгийн ард түмний амьдралд тус болдоггүй байв. Ихэнх энэтхэгчүүдийн амьдрал туйлын хүнд, ядуучууд ихтэй байлаа. Энэ нь учир шалтгаантай вэ?

8.2д

.....
.....
.....
.....




ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС



Хүүхдүүд та бүхэн өөрийгөө үнэлэхдээ “Өөрийн үнэлгээ” гэсэн хүснэгтэд даалгаврын дугаараа тавиарай. Жишээ нь: Бүрэн хийж чадсан даалгаврынхаа дугаарыг “Би хийж дууссан” гэсэн нүдэнд тавиарай.



1. Өөрийн үнэлгээ

 Би хийж дууссан	 Би эргэлзэж байна	 Надад дууламж хэрэгтэй байна



2. Багшийн үнэлгээ

<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
--